

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр, Баасан гараг

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	-
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	1-3
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	4-6
<hr/>	
1. Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай	4-6

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Төрийн байгуулалтын байнгын хорооны 12 дугаар сарын 20-ны өдөр  
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 23 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: С.Амарсайхан, О.Алтангэрэл, С.Бямбацогт, Ц.Туваан;  
Чөлөөтэй: Э.Болормаа, Л.Гантөмөр, Л.Оюун-Эрдэнэ, Ө.Шижир;  
Эмнэлгийн чөлөөтэй: Э.Одбаяр.

**Нэг.Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар  
хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг  
чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх Б.Хатантуул, референт А.Наранцэцэг, мөн албаны Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны референт Э.Баттогтох нар байлцав.

Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Ж.Бат-Эрдэнэ:** 1.Засгийн газар 2024.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны 3 дугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг, төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 5  
Бүгд: 15  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 5 гишүүн 2024.12.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь, хэмжээ тогтоохгүй байх, гадаад ажилтны ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай хуулийн

төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 5  
Бүгд: 15  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Засгийн газар 2024.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 4  
Бүгд: 15  
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд нарын 101 гишүүн 2024.12.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, “Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 4  
Бүгд: 16  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Засгийн газар 2024.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 5  
Бүгд: 16  
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

*Уг асуудлыг 12 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 10 минут үргэлжилж, 25 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 64.0 хувийн ирцтэйгээр 12 цаг 33 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**  
2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр,  
Баасан гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим 12 цаг 23 минут.

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Ж.Бат-Эрдэнэ:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Ингээд Байнгын хороонд оролцож байгаа гишүүдийн танилцуулъя.

Дашзэвэгийн Амарбаясгалан гишүүн, Их Хурлын дарга ирсэн байна. Баярмагнайн Баярбаатар гишүүн ирсэн. Сархадын Зулпхар гишүүн ирсэн. Нямтайширын Номтойбаяр гишүүн ирсэн. Одонгийн Цогтгэрэл гишүүн ирсэн. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн ирсэн. Жудагийн Баярмаа гишүүн ирсэн. Лхагвын Мөнхбаатар гишүүн ирсэн. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн ирсэн. Батын Батбаатар гишүүн ирсэн. Тогмидын Доржханд гишүүн хүрэлцэн ирсэн. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн ирсэн. Гончигдоржийн Уянгахишиг гишүүн ирсэн. Одонгийн Цогтгэрэл гэж хэлсэн байх тийм ээ, гишүүн ирсэн байна.

Ингээд ирц бүрдсэн тул 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1 асуудал байна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай.

1. Монгол Улсын Улаанбаатар хотын дулааны 3 дугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг, төсөл боловсруулах тухай. Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл,

2. Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээ тогтоохгүй байх, гадаад ажилтны ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 5 гишүүн 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн хууль,

3. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Засгийн газар 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн,

4. “Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэболд нарын 101 гишүүн 2024 оны 12 сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн,

5. Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл. Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн хууль байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор санал хэлэх гишүүд байна уу?

Цэцийн, бид нарын түрүүний нөгөө хуралдаанаар хэлэлцэх гэж байсан уу? Тэр чинь орчихсон байгаа биз дээ. Орчихсон байгаа, ирэх 7 хоногт хэлэлцээд явчихна. Тийм.

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор саналтай гишүүд байвал саналаа хэлнэ үү? Байхгүй юу. Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

**1. Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцье.**

Засгийн газар 2024 оны 12 сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн. Монгол Улсын Улаанбаатар хотын дулааны 3 дугаар цахилгаан станцын өргөтгөл шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт 66,7 хувиар санал дэмжигдлээ.

2. Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 5 гишүүн 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн, Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь, хэмжээ тогтоохгүй байх, гадаад ажилтны ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 15 гишүүн оролцсоноос 10 гишүүн дэмжиж, 66,7 хувиар санал дэмжигдлээ.

3. Засгийн газар 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 15-аас 11 гишүүн дэмжиж, 73,3 хувиар санал дэмжигдлээ.

4. Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд нарын 101 гишүүн 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн, “Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 16 гишүүнээс 12 гишүүн оролцож, 75 хувиар санал дэмжигдлээ.

5. Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн хуулийн төсөл Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 16 гишүүнээс 11 гишүүн оролцож, 68,8 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцэж шийдвэрлэлээ.

12.33 цаг

Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудал дууссан тул энэ өдрийн хуралдааныг өндөрлөснийг мэдэгдье.

Баярлалаа гишүүддээ.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ